

Могойн гол ХК-ийн Бизнесийн үйл ажиллагааны

2015 оны ажлын тайлан

Эрхэм хүндэт ТУЗ-ийн дарга, гишүүд та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Манай компанийн хамт олон бид МУ-ын компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн хурлын шийдвэр, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагын удирдамж, чиглэлийг хэрэгжүүлэн, 2015 оны бизнес төлөвлөгөөг хугацаанд нь ханган биелүүлэхийн төлөө бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллаж ирснээ та бүхэнд хүргүүлж байна.

❖ Удирдлага, зохион байгуулалтын талаар

Тайлангийн хугацаанд хувь нийлүүлэгчдийн хурлыг 2, ТУЗ-ийн хурлыг 14 удаа хуралдуулж 2014 оны ажилд үнэлэлт дүгнэлт гаргуулж, 2015 оны үйлдвэрлэлийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, үйлдвэрийн түүхий эд материалыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж цаашдын ажилд чиглэл удирдлага болгон ажиллахаас гадна цаг үеийн асуудлаар холбогдох шийдвэрүүдийг гаргууллаа.

2015 онд захирлын 52 тушаал гаргаснаас боловсон хүчний холбогдолтой 36, үйл ажиллагааны холбогдолтой 16 тушаал тус тус гаргалаа. Байгууллагын хэмжээнд 3 эрх зүйн баримт бичгийг шинэчилж, 7 баримт бичгийг шинээр боловсруулан дагаж мөрдөж байна. Үүнд: Хөдөлмөрийн дотоод журам, Ажилчдын хөдөлмөрийн гэрээ, Ажлын цаг ашиглалтын журмыг шинэчилж, Орон сууц барихад дэмжлэг үзүүлэх журам, Компанийн ажилчдын ёс зүйн дүрэм, Ёс зүйн хорооны ажиллах журам, Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ, Ажилтан ажилд авах журам, Орон сууц хөлслүүлэх гэрээ, Шуурхай болон сонсгол хийх журмыг шинээр боловсруулав.

Мөн хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалан баталгаажуулах, үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэх, тогтвортой ажиллагааг хангах, хөдөлмөрийн харилцаатай холбогдсон асуудлыг зохицуулах зорилгоор Үйлдвэрчний байгууллагатай хамтын гэрээг 2 жилээр шинэчлэн байгуулан ажиллаж байна. Компанийн дотоод хяналтын нэгжийг байгуулан үйлдвэрийн түүхий эд материалын зарцуулалт, өмч хөрөнгийн ашиглалт, ХАБЭАболон үйлвэрийн процесст хяналт тавин холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүллээ

❖ Үйлдвэрийн үйл ажиллагааны талаар:

2015 оны хөрс хуулалтын ажлыг 2-5-р огтлолын хооронд 1880-1900-р түвшинд ЭКГ-5А, КАТ экскаватор, ECD-45E өрмийн машин 1, SD HYUNDA-520 экскаваторыг -8 бульдозер 1, өөрөө буулгагч автосамосвал 8, ус зөөврийн МАЗ цистерн 1, үйлчилгээнд маяти авто машин 1, пуругон автомашин 1, шинээр 3 м3-ын багтаамжтай шанагатай экскаватор 1-ийг нэмж худалдан авч ашиглан нийтдээ 66 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Төлөвлөгөөт зорилтыг ханган биелүүлэхэд шаардлагатай үйлдвэрийн гол түүхий эд болох түлш, шатахуун тосолгооны материал, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулан төлөвлөгөөний дагуу хууль журмын хүрээнд нээлттэй тендер зарлан шалгаруулж, 150,3 мянган литр дизель түлш, 22,3 мянган литр бензин /үнийн дүнгээр 258306,7 мянган төгрөг/, 116 тн /үнийн дүнгээр 186.3 сая төгрөгийн / тэсрэх материал, 138,0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэлийн нөөц бэлтгэв. 2015 оны 3-р сарын 9-өөс нийт ажилчдын дунд ХАБЭА-н болон техник ашиглалтын талаар 7 хоног 40 цагийн сургалт явуулж, техникийн засвар үйлчилгээг 3-р сарын 17-оос 4-р сарын 5-д хийж дуусгасан. ХЕРА компаниас HYUNDA-520 экскаваторыг 699.0 сая төгрөгөөр 1 жилийн хугацаатай лизенгийн зээлээр худалдан авч зээлийн хүүд 50.0-иад сая төгрөг төлж байна. ЭКГ-5А цахилгаан экскаваторын 20 гаруй эд ангиуд элэгдэн ажиллуулах боломжгүй болсон тул Эрдэнэт үйлдвэрийн засварын механикийн заводтой гэрээ хийж, эд ангиудыг шинээр хийлгэж, сэргээн засварлуулж ирүүлэн угсарч экскаваторын засварын ажил 4-р сарын 24-д дууссан. 4-р сарын 27-д ажилд орсноор хөрс хуулалтын ажил жигдэрч хэвийн горимд шилжсэн. Хөрс хуулалтын ажлыг 2 ээлжээр хоногт 16 цагаар ажиллуулж, 4-10-р сарын хооронд 7 сарын хугацаанд сарын 50.0 мянган м3-ийг хийхээр төлөвлөж ЭКГ-5А экскаватороор 2015 онд 200.4 мянган м3 тэсэлгээтэй хөрс, HYUNDA-520 экскаватороор 153,8 мянган м3 тэсэлгээгүй хөрс тус тус ачсан байна.

Нүүрс ачилтыг тэсэлгээний тусламжтайгаар КАТ-320 экскаватороор гүйцэтгэж байна. Хөвсгөл Завхан аймгийн 95 байгууллага аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. 2015 онд Хөвсгөл аймагт 19,7 мянган тн, үүнээс ДСтанцад 6,7 мянган тн, Завхан аймагт 17,1 мянган тн, Могойн гол-Эиержи ХХК-д 9,7 мянган тн нүүрс нийлүүлээ.

❖ **Үйлдвэрийн төлөвлөгөөт зорилтын биелэлтийн талаар:**

2015 онд 350.0 мянган м3 хөрс хуулалтын ажил хийж, 50.0 мянган тн нүүрс олборлон борлуулах зорилт тавин ажиллаж, 354,2 мянган м3 хөрс хуулалтын ажил хийж 46,5 мянган тн нүүрс борлуулсан байна. Тайлант хугацаанд хөрс хуулалтын төлөвлөгөө 101,2 хувийн биелэлттэй байгаа нь урд оны мөн үетэй харьцуулахад хөрс хуулалтын ажил 65,7 мянган м3 буюу 22.8 хувиар давж, нүүрсий борлуулалтын төлөвлөгөө 93,0 хувиар биелж, урд онтой харьцуулахад 0,8 мянган тн буюу 1,8 хувиар өссөн байна. 2015 онд 1565000.0 мянган төгрөгийн борлуулалт хийж,

1494815,7 мянган төгрөгийн зардал гарган, 70184,3 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөж, тайлант онд 1493309,8 мянган төгрөгийн борлуулалт хийж, 1413801,7 мянган төгрөгийн зардал гарган 79508,1 мянган төгрөгийн ашигтай ажиллаж байна. Борлуулалтын төлөвлөгөө 95,4 хувиар биелж, урд оны мөн үетэй харьцуулбал 97,3 хувьтай байна. Нийт зардал төлөвлөсөн хэмжээнээс 5,4 хувиар, урд оны мөн үеээс 1,7 хувиар тус тус буурч, тайлант онд цэвэр ашиг төлөвлөсөн хэмжээнээс 13,3 хувиар өсч, урд оноос 18 хувиар буурсан байна. Борлуулалт буурсан шалтгаан нь цаг агаарын дулаарал, эдийн засгийн хямарлаас болж замын бүтээн байгуулалтын ажил зогссонтой холбоотой ба борлуулалт буурснаас ашиг буурсан байна.

❖ Хөрөнгө санхүүгийн талаар

Тайлант онд компанийн нийт хөрөнгө 3207792,6 мянган төгрөг байгаа бөгөөд урд оноос 376649,1 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт хөрөнгийг дотор нь задалбал: дансан дахь мөнгө 6712,5 төгрөг, урд оноос 61,2 дахин багассан, нийт авлага 278470,4 мянган төгрөг, урд оноос 98,2 хувиар өссөн, бараа түүхий эд материал урьдчилж гарсан зардал 776261,5 мянган төгрөг, урд оноос 68,7 хувиар өссөн, эргэлтийн бус хөрөнгө 12146348,1 мянган төгрөг, урд оноос 17,9хувиар өссөн байна. Шинэ тоног төхөөрөмж лизенгийн зээлээр худалдан авч төлөлт хийснээр мөнгөн хөрөнгө буурсан. Боловсролын байгууллагуудын халаалтын санхүүжилт хийгдээгүйгээс Дулааны станцаас авах 180 гаруй сая төгрөгийн нүүрсний үнийг авч чадаагүйгээс авлага өссөн. Дараа жилд шилжих 22.5 мянган тн нүүрсийг данс бүртгэлд тусгаснаар БТЭМ нэмэгдсэн.

❖ Өр төлбөр эзэмшигчийн өмчийн талаар

Өр төлбөр эзэмшигчийн өмчийн дүн 3207792,6 мянган төгрөг байгаагийн 353881,2 мянган төгрөг нь богино хугацаат өр төлбөр бөгөөд урд оноос 10,4 дахин нэмэгдэж, дансны өглөг 283989,2 мянган төгрөг, татварын өглөг 48589,8 мянган төгрөг, НДШ-ийн өглөг 11717,6 мянган төгрөг, бусад богино хугацаат өр 1288,4 мянган төгрөг, олгохоор тооцсон ногдол ашгийн өглөг 8296,2 мянган төгрөг байна. Урт хугацаат өр төлбөр 1010895,0 мянган төгрөг, эздийн өмчийн дүн 1843016,4 мянган төгрөг байгаа нь тайлант оны цэвэр ашиг 79508,1 мянган төгрөгөөр өсч, ногдол ашиг 8296,2 мянган төгрөгөөр буурсан. Богино хугацаат өглөг 10,4 дахин нэмэгдсэн нь лизенгээр худалдан авсан тоног төхөөрөмжийн үнэ 258,0 сая төгрөгийг 2016 онд төлөхөөр тохиролцсон.

❖ Нийгмийн асуудлын талаар

Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хийсэн хамтын гэрээг үндэслэн ажилчдын нийгмийн асуудлаар дараахь ажлуудыг хийж гүйцэтгэв.

Ажилчдын цайны газрын ажиллагааг жигдэрүүлж, нийт ажилчдад 70 хувийн хөнгөлөлттэй үнээр халуун хоол цайгаар үйлчлэн 13207,5 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүллээ. Уулын үйлдвэрийн болон засварын ажилчдыг өдөрт үнэгүй халуун усанд оруулж байна.

Компанийн өндөр настануудад тэтгэмж, хүлээн авалтанд 2048.8 мянган төгрөг зарцууллаа. Мөн өндөр насны тэтгэвэрт гарч байгаа 2 ахмад ажилтанд 8136,0 мянган төгрөгийн тэтгэмж олгов. Ажилчдын өвлийн түлшний хэрэгцээнд нүүрсийг 50 хувь хөнгөлж 2975,0 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүллээ. Уй гашуу тохиолдсон болон хүндээр өвдсөн 4 ажилтанд 2300.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн. Уурхайчдын баяр, шинэ жил, эмэгтэйчүүд, хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд 2623,9 мянган төгрөг, ажилчдыг шагнаж урамшуулахад 1000,0 мянган төгрөг, шинээр гэр бүл болсон 2 ажилтанд 400,0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

❖ **Компанийн нийгмийн хариуцлагын талаар:**

Тус компани тайлант хугацаанд улс орон нутгийн төсөвт 404708,6 мянган төгрөгийн татвар, шимтгэл төлсөн байна. Нийт татвар шимтгэлийг задалж харуулбал: НӨАТ-т 178759,4 мянган төгрөг, ашигт малтмалын нөөцийн төлбөрт 36491,2 мянган төгрөг, Үл хөдлөх хөрөнгийн татварт 10088,0 мянган төгрөг, ХАОАТ-т 39350,4 мянган төгрөг, бусад татварт 3739.4 мянган төгрөг, Агаарын бохирдолын татвар 22495 мянган төгрөг, ААНОАТ-т 8834,2 мянган төгрөг, ЭМНД-ын шимтгэлд 104951,0 мянган төгрөг байна. Тайлант онд төлсөн татвар хураамжийг урд онтой харьцуулахад 12,1 хувиар буюу 43820,3 мянган төгрөгөөр өссөн байна.

Монгол улсын татварын албанаас манай компанийг Монгол улсын татварын хууль тогтоомжийг шударгаар сахиж, улс орны хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулан нийгмийн хариуцлагаа нэр төртэй биелүүлж байгааг үнэлэн 2014 оны тэргүүний татвар төлөгч ААН-ээр шалгаруулан “**Хөх дэвтэр**” цом, батламж олгосон

Аймгийн ИТХ-ын хүсэлтээр Хурлын санал тоолох системийн тоног төхөөрөмжийг 20.0 сая төгрөгөөр санхүүжүүлэв. Цэцэрлэг сумын 6 багийн амьдралын баталгаат түвшингээс доогуур орлоготой 180 иргэний Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн жилийн төлбөрийг байгууллагаас төлсөн. Сумын ажилгүй 11 иргэнийг ажилд авав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны ажлын талаар

“Могойн гол”ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь өнгөрсөн тайлант хугацаанд компанийн үйлдвэрлэл ,удирдлага зохион байгуулалт санхүү эдийн засгийн асуудлаар зайлшгүй шийдвэл зохих 20 асуудал хэлэлцэж, тухай бүрд нь хурлын тэмдэглэл хөтөлж холбогдох тогтоол шийдвэр гаргасан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн байдаг орон зайнаас шалтгаалан ТУЗ-ийн хурлыг 2 хэлбэрээр хийж байсан юм.

Гишүүдийн биечлэн оролцсон хурлыг 3 удаа хийж 13 асуудал, зарим яаралтай шийдэх асуудлыг шийдвэрлэхийн тулд цахилгаан шуудангаар /онлайн/ санал авах хурлыг 4 удаа хийж 7 асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргалаа.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн хэлэлцсэн асуудлыг ангилан үзвэл

- a. Компанийн бизнес төлөвлөгөө,худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, компанид , нүүрсний үнэ нэмэх, нэмэлт хувьцаа гаргах тухай гэх мэт үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой 4 асуудал хэлэлцэж 6
 - b. Компанийн ТУЗ-ийн дарга гишүүдийг сонгох, удирдах ажилтны гүйцэтгэлийн хариуцлагатай холбогдсон асуудал, ТУЗ-ийн дэргэдэх хороо байгуулах,хороодын журам батлах хувь нийлүүлэгчидийн хурал зохион байгуулах зэрэг удирдлага зохион байгуулалттай холбоотой 13 асуудал ТУЗ-ийн хуралд хэлэлцсэн асуудлаар нийт 19 тогтоол гарсан бөгөөд 1 асуудлыг мэдээлэл ярилцлагын хэрбэрээр сонгон шийдэж байв.
- 2015 онд 350.0 мянган м3 хөрс хуулалтын ажил хийж, 50.0 мянган тн нүүрс олборлон борлуулах зорилт тавин ажиллаж, 354,2 мянган м3 хөрс хуулалтын ажил хийж 46,5 мянган тн нүүрс борлуулсан байна. Тайлант хугацаанд хөрс хуулалтын төлөвлөгөө 101,2 хувийн биелэлттэй байгаа нь урд оны мөн үетэй харьцуулахад хөрс хуулалтын ажил 65,7 мянган м3 буюу 22.8 хувиар давж, нүүрсий борлуулалтын төлөвлөгөө 93,0 хувиар биелж, урд онтой харьцуулахад 0,8 мянган тн буюу 1,8 хувиар өссөн байна. Нийт зардал төлөвлөсөн хэмжээнээс 5,4 хувиар, урд оны мөн үеээс 1,7 хувиар тус тус буурч, тайлант онд цэвэр ашиг төлөвлөсөн хэмжээнээс 13,3 хувиар өсч, урд оноос 18 хувиар буурсан байна. Борлуулалт буурсан шалтгаан нь цаг агаарын дулаарал, эдийн засгийн хямарлаас болж замын бүтээн байгуулалтын ажил зогссонтой холбоотой ба борлуулалт буурснаас ашиг буурсан байна.
 - Уурхайн 2016 оны үндсэн төлөвлөгөө болон хэтийн төлөвийн тухай асуудлыг хэлэлцээд 2016 онд хуулах нийт хөрсний хэмжээг 300 мянган М3, нүүрс олборлолт 60 мянган тонн, нүүрс борлуулалт 40мянган тонн байхаар бизнес төлөвлөгөөг баталсан байна.

- “Могойн гол”ХК-ийн захираа хооронд байгуулсан хамтын гэрээний 5.5 заалтыг “Компанид ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарч байгаа ажилтанд компанид ажилласан жил тутамд нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ /192000 төгрөг/-г нэмэгдүүлэн бодож тэтгэмж олгоно.” , мөн гэрээний 5.6 дугаар заалтыг “Компанийн ажилчин, албан хаагчдад орон сууц шинээр барихад зориулж 1 удаа 1000000 /нэг сая/ төгрөгийн дэмжлэг тусламж үзүүлнэ.” гэсэн заалтын хамтын гэрээнд тусгасан байна.

- “Могойн гол”ХК-ийн хувьцаа эзэмшигчидийн ээлжит бус хурал 2015 оны 11-р сарын 09-ний өдөр хуралдаж компанийн Нэмэлт хувьцаа гаргах тухай хэлэлцэж хуралд нийт саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчидийн 51 хувь санал ирүүлсэн бөгөөд хэлэлцэж буй асуудалтай холбогдон гаргасан хурлын шийдвэрийг 100%-ийн саналаар баталсан байна.

- “Могойн гол”ХК 2016 оны 02-р сарын 13-ны байдлаар 829622 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд манай компанийн хувьцаа “Үнэт цаасны төлбөр тооцоо хадгаламжийн төв”ХХК-д хадгалагдаж байгаа бөгөөд “Булган брокер” Дархан брокер”, “Би Ди сек” зэрэг брокер диллерийн 51 компанид 968 хувьцаа эзэмшигчийн нэр дээр хадгалагдаж байдаг.

Компанийн ТУЗ Монгол улсын компанийн тухай хууль, компанийн дүрмийг үндэс болгон цаашдын үйл ажиллагааны мөрдлөг болгон ажиллах болно.

Анхаарал тавьсанд баярлалаа